



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/82

Өвт

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.4, 46.1.6 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр зөвлөмжийг үндэслэн Орхон бага сургуулийн хүүхдийн үдийн цай нийлүүлэх багц-2-ийг "Өвт хайрхан" хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. "Өвт хайрхан" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Орхон бага сургуулийн хүүхдийн үдийн цай нийлүүлэх багц- 02 зардалд шаардагдах 1 982 000 (Нэг сая есөн зуун наян хоёр мянга) төгрөгийг гэрээний дагуу санхүүжүүлэхийг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Ц.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010163